



## Монголын Андууд™ ТББ Оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөр 2013-2014

Монголын Андууд™ ТББ нь АНУ болон Монгол Улсын үндэсний төрийн байгууллагад бүртгэгдсэн байгууллага юм. Энхтайвны Корпусын сайн дурын мэргэжилтнүүдийн санаачилгаар анх байгуулагдаж Америк Монгол 2 орны харилцаа холбоо, соёлын солилцоо болон Монголын хүүхэд залуучуудын боловсрол, хөгжил, соёлыг дэмжих зорилготойгоор ажиллаж байна.

Энэ жил Монголын Андууд™ ТББ нь 4 төрлийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт оюутнуудыг хамруулах гэж байгаа нь бахархууштай байна. Тэтгэлэг тус бүрийг товч танилцуулахад:

/бусад мэдээллийг тэтгэлэгт хамрагдах өргөдөлөөс үзнэ үү/

### Монголын Андууд™ ТББ-ын Эрэгтэй оюутнуудын тэтгэлэгт хөтөлбөр:

11-р анги төгссөн болон одоо Монголын их, дээд сургууль, МСҮТ-д хөдөө орон нутгаас ирж суралцаж байгаа өмнөө тавьсан тодорхой зорилготой, өөрийгөө удирдах чадвартай эрэгтэй оюутнууд хамрагдах хөтөлбөр. Монголын Андууд™ ТББ-ын тэтгэлгийн сангаас болон Хаан Банк сангаас санхүүжигднэ.

#### Тавигдах шаардлага:

- |                                       |   |
|---------------------------------------|---|
| ✓ Улаанбаатарын бус харьяалалтай байх | ✓ Их, дээд сургууль болон МСҮТ-д элсэн орсон байх |
| ✓ 11 дүгээр анги төгссөн байх         | ✓ В-ээс дээш үнэлгээтэй байх                      |
| ✓ 25-аас доош настай байх             | ✓ Санхүүгийн хэрэгцээгээ тодорхойлсон байх        |

### Мэтью Гервиний тэтгэлэгт хөтөлбөр:

Мэтью Гервин нь 2001 онд Монголд НҮБ-ийн Хүүхдийн сан хөтөлбөрийн ажилтанаар ажиллаж байхдаа осолд орж харамсалтайгаар нас барсан билээ. Мэтью Ли Гервиний ар гэрийнхэн нь дурсгалд нь энэхүү тэтгэлэгийг бий болгосон юм. Мэтьюгийн хүүхэд залууст туслах хүслийг үргэлжлүүлэн найз нөхөд болон НҮБ-ийн Хүүхдийн сангийн төлөөлөгчид энэхүү тэтгэлэгийг дэмждэг билээ. Уг тэтгэлэгт анагаах ухаан, боловсрол, шинжлэх ухаан болон байгаль орчны чиглэлээр сурч буй оюутнууд хамрагдах боломжтой.

#### Тавигдах шаардлага:

- |                                       |   |
|---------------------------------------|---|
| ✓ Улаанбаатарын бус харьяалалтай байх | ✓ Их, дээд сургууль болон МСҮТ-д элсэн орсон байх |
| ✓ 11 дүгээр анги төгссөн байх         | ✓ В-ээс дээш үнэлгээтэй байх                      |
| ✓ 25-аас доош настай байх             | ✓ Санхүүгийн хэрэгцээгээ тодорхойлсон байх        |

### Крофтын гэр бүлийн Баянхонгор аймгийн Баянхонгор сум болон Төв аймгийн Баянчандмань сумын суралцагч оюутнуудад олгох тэтгэлэгт хөтөлбөр:

Крофтын гэр бүл болох Лэетон ба Алисон, тэдний 2 хүү энэ жил хэд хэдэн тэтгэлэг өгч байгаа. Лэетон нь Баянхонгор сум дахь Энхтайвны Корпусд, Алисон нь Баянчандмань сум дахь Энхтайвны Корпусд тус тус ажиллаж байсан ба энэ тэтгэлэгтээ эдгээр 2 сумаас оюутнуудыг хамруулахыг хүсч байна.

#### Тавигдах шаардлага:

- |                               |   |
|-------------------------------|---|
| ✓ 11 дүгээр анги төгссөн байх | ✓ Баянхонгор аймгийн Баянхонгор сум, Төв аймгийн Баянчандмань сумын харьяалалтай байх |
| ✓ В+-ээс дээш үнэлгээтэй байх | ✓ Их, дээд сургууль болон МСҮТ-д элсэн орсон байх                                     |
| ✓ 25-аас доош настай байх     | ✓ Санхүүгийн хэрэгцээгээ тодорхойлсон байх  |

### Бүх тэтгэлэгт хөтөлбөр:

Монголын Андууд ТББ нь Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд байрлах Монголын их, дээд сургуулиудад суралцаж буй суралцах хүсэл эрмэлзэлтэй хэдий ч санхүүгийн бэрхшээлийн улмаас суралцахад хүндрэл тулгараад буй оюутнуудад бүтэн жилийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж ажилладаг юм.

Тэтгэлэгт хөтөлбөрийн гол зорилго нь их, дээд сургууль болон МСҮТ-д хөдөө орон нутгийн оюутнуудын тоог нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү тэтгэлэг нь Монгол Улсын бүх аймаг бүсээс нэр дэвшигчийг сонгон шалгаруулна.

Дээрх тэтгэлэгүүдэд нэн ядуу бөгөөд санхүүгийн тусламж зайлшгүй шаардлагатай гэсэн үндэслэлийн дагуу өргөдөл гаргагчийг сонгож тэтгэлэг олгох болно. Сургалтын төлбөрийг Монголын Андууд™ ТББ-ын данснаас тухайн оюутны суралцаж буй сургуулийн дансруу банкаар дамжуулан шилжүүлнэ. Тэтгэлэгт хөтөлбөр болон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах өргөдлийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл [sarangoo@zorifoundation.org](mailto:sarangoo@zorifoundation.org) гэсэн хаягруу захиа бичих болон 99053732 гэсэн утасруу холбогдоно уу?



**ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

- МОНГОЛЫН АНДУУД ТББ-ын эрэгтэй оюутнуудын тэтгэлэг
- МЭТЬЮ ГЕРВИН-ий тэтгэлэгт хөтөлбөр
- КРОФТЫН ГЭР БҮЛИЙН тэтгэлэгт хөтөлбөр

**ЗУРАГ**

**ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ:**

Нэр: \_\_\_\_\_ Овог: \_\_\_\_\_

Регистрын дугаар: \_\_\_\_\_ Утасны дугаар: \_\_\_\_\_

Шаардлагатай тохиолдолд холбоо барих хүний утасны дугаар, овог нэр, ямар хамааралтай болох

**БОЛОВСРОЛ:**

Одоо суралцаж буй их сургууль \_\_\_\_\_

Факультет \_\_\_\_\_ Мэргэжил \_\_\_\_\_ Курс \_\_\_\_\_

Суралцсан хугацааны голч дүн \_\_\_\_\_

Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрт хэд дэх удаа өргөдөл гаргаж байгаа вэ?

- Анх удаа
- Бусад (тоог бичнэ үү) \_\_\_\_\_

Сургалтын ямар нэг тэтгэлэг, санхүүгийн туслалцаанд хамрагдаж байсан уу?

- Тийм (хэрэв тийм бол ямар тэтгэлэг, хэдий хэмжээтэйгээр авч байсан бэ?) \_\_\_\_\_

- Үгүй

**ГЭР БҮЛИЙН ТАЛААРХ АСУУЛТУУД:**

Ам бүлийн тоо: \_\_\_\_\_

Өрхийн сарын орлого: \_\_\_\_\_

Ам бүлийн гишүүдийн нэрс, хамаарал (аав, ээж, ах, эгч г.м)	Нас	Одоо хаана, юу хийдэг?

## ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДАХ ӨРГӨДӨЛ-Асуултууд

Асуултууд: (хуудас бүрт өөрийн нэр болон иргэний үнэмлэхний дугаараа бичнэ үү.)

1. Суралцах хугацаанд гаргасан амжилт, шагнал урамшууллаа жагсаан бичнэ үү.
2. Нийгмийн идэвхи болон ажлын туршлагын талаар бичнэ үү.
3. Өөрийн ирээдүйн ажил мэргэжлийн зорилго, төлөвлөгөө болон сонгосон шалтгааний талаар эссэ бичнэ үү. /1-с илүүгүй хуудас/
4. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлт бичнэ үү! Уг хүсэлтэнд өөрийн товч намтар, хувийн сонирхол, гэр бүлийн мэдээлэл орсон байх шаардлагатай. /1-с илүүгүй хуудас/

**Жич: Хугацаа хоцорсон болон дутуу материалыг шалгаруулалтанд оруулахгүй болохыг анхаарна уу. Мөн бүх материалууд өргөдөл гаргагчийн нэр ба регистрын дугаартай байна. Материалыг буцааж олгохгүй.**

Доорх зүйлсийн бүрэн эсэхийг шалган тэмдэглэгээ хийнэ үү.

- Өргөдлийн маягтыг бүрэн бүтэн бөглөсөн.
- Суралцсан хугацааны дүнгийн хуулбар, хэрэв их, дээд сургуульд элсэгч бол ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар.
- Өөрийн оршин суудаг газрынхаа төр захиргааны байгууллагаас гэр бүлийнхээ сарын өрхийн орлогыг тодорхойлуулж баталгаажуулсан байна.
- Иргэний үнэмлэхний хуулбар.
- Эссэ бүрийг нэг нэг хуудсанд багтаан бичсэн байна.
- Их, дээд сургууль, МСҮТ-д элсэн орсон эрхийн бичгийн хуулбар.

## БАТАЛГАА:

Дээрх өгсөн мэдээлэлд өргөдөл гаргагч миний бие бүрэн хамааралтай ба үнэн зөв болохыг баталж байна. Миний сонгох тэтгэлгийн хандивлагч болох этгээд болон хандивлагчид мөн Монголын Андууд байгууллагад өргөдөлд орсон мэдээллийг шалгах зөвшөөрлийг өгч байна.

\_\_\_\_\_  
/Гарын үсэг/

\_\_\_\_\_  
/он, сар, өдөр/

Нэр:

**ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ СҮҮЛИЙН ХУГАЦАА: 2013-08-15  
30**

Регистрын дугаар:

**ДҮН ГАРАХ ХУГАЦАА: 2013-08-**